



Гуравдугаар ангийн суралцдын унших чадварын чанарын асуудал

Г.Бямбацэрэн

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр дээд сургууль

Холбоо барих зохиогч: byatsrn@gmail.com 

Хүлээн авсан: 2020.05.15

Хянагдсан: 2020.09.10

Зөвшөөрсөн: 2020.09.28

Хураангуй

Суралцагч унших хэмээх тогтолцоо бүхий чадварт суралцахдаа зөв уншиж сураагүй бол хурдан уншихгүй, хурдан унших арга барил эзэмшээгүй бол ойлгож уншихгүй. Унших чадварыг хөгжүүлэх багш өөрөө унших арга барилтай, басхүү зөв уншуулж сургахын тулд авиа зүйн мэдлэгтэй байхын зэрэгцээ өнөөгийн суралцагчдад унших чадвар хамгийн чухал гэдгийг мэдэрдэг байх. Гэтэл багш хурдан уншлагыг дэмжих 1-2 арга, ойлгож унших 3-5 арга хэрэглэхээс цаашгүй, түүнчлэн хичээлийн цагийн 80 хүртэлх хувийг бичих чадварыг хөгжүүлэхэд зарцуулж байгаа нь бага ангийн суралцагчдын унших чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг болж чадахгүй байгаа хүчин зүйлүүд гэж үзлээ.

Түлхүүр үг

Унших тогтолцоо, хурд, дээд эрэмбийн асуулт, сэтгэхүйн үйл, арга зүй

Удиртгал

Хэл тогтолцоо бөгөөд хэлний чадвар болох унших чадварт суралцана гэдэг тогтолцоо бүхий цогц чадварт суралцана гэсэн үг. Гэтэл өнөөдөр унших гэдгийг карт цээжлээд түр зуурын ой үүсгэхийг уншиж сурлаа, эх цээжлээд ямар ч агуулгатай байсан гараа хөдөлгөөд чангаар уншихыг мэдэрч уран уншлаа, унших чадвартай гэж үзэх буруу хандлага бий болж байна. Зөв уншиж сураагүй суралцагч хурдан уншихгүй, хурдан уншиж сураагүйгээр ойлгож уншихгүй, ойлгож уншаагүй суралцагч уншсанаа илэрхийлж урнаар уншихгүй улмаар бичих чадвараа хөгжүүлж чадахгүй. Уншиж ойлгох чадвар нь оюуны үйлдлийн талаасаа хүртэхүй (perception) болон сэтгэхүй (thought) хоёрыг багтаасан нарийн бөгөөд цогц үйл (Бурмаа, 2011, х.31). Гуравдугаар ангийн суралцагч өнөөдөр энэхүү цогц үйлийн ойлгож унших арга барилыг түлхүү эзэмшиж байх ёстой. 2017, 2019 онд хийгдсэн EGRA-гийн судалгаа 1, 2 дугаар ангийн суралцагчийг хамарч хийгдсэн бөгөөд уншаад ойлгох чадварын судалгааны үр дүн 23% гэж их тааруухан гарсан. Цөм хөтөлбөрийн хүлээж буй үр дүн, энэхүү судалгааны үр

дүн зэрэгт суурилан 3 дугаар ангийн суралцагчийн унших чадвар, түүнийг хөгжүүлж буй арга зүй хэрхэн хэрэгжиж байгааг тандах зорилгоор бичил судалгаа хийсэн.

Уг судалгаанд үйлийн судалгаа зэрэг судалгааны эмпирик арга зүйг ашиглалаа. Олон улсын уншихын нийгэмлэгийн боловсруулсан EGRA-гийн аргачлал, хэрлэгдэхүүнээр монгол хүүхдийн унших чадварыг судалсан судалгааны үр дүн, арга зүйг судалж боловсруулалт хийх, багш нараас асуулга, фокус бүлгийн ярилцлага, суралцагчийн унших чадварыг хөгжүүлж буй арга, тэдний ойлгож унших чадварыг үйлийн эргэцүүллийн тэмдэглэл (Thinking aloud protocols) хийж чанарын болон тоо мэдээлэл цуглуулж, статистикийн SPSS программ, анкетын судалгаанд боловсруулалт хийж гуравдугаар ангийн сурагчдын ойлгож унших чадвар, түүнийг хөгжүүлж буй аргыг судаллаа.

Унших чадвар

Эцэг эхчүүд, багш нар хүүхдээсээ “хурдхан” унших чадвартай болохыг хүлээж байдаг бөгөөд тэд ихэвчлэн үсгийн код (Anderson)-ыг тайлж, утгыг ойлгохыг унших чадвартай болчихлоо хэмээн дутуу ойлгодог. Зарим эцэг эхчүүд бүр яарч 2-4 насанд нь карт нүдлүүлж, нүдэлснээ алдаагүй дуудаж байвал уншаад сурчихлаа гэж эндүүрэх. Гэтэл ... уншина гэдэг нь энгийнээр томьёолбол асуулт тавьж түүнийхээ хариултыг тухайн эхээс олж авах асуудал юм (Smith, F.1997, Reading Without Nonsense) (Бурмаагийн эшилснээс, 2011, х.32). “... уншиж ойлгох үйл нь өөрөө сэтгэл зүйн таавар, тодруулбал, энэ нь хэл сэтгэхүй хоёрын харилцан үйлчлэл бөгөөд уншиж ойлгоно гэдэг тухайн эхийг бүрдүүлж байгаа хэсгүүдийг бүгдийг ойлгох асуудал бус харин таамаглалаа зөв дэвшүүлэхэд хамгийн тустай цөөн хэдэн гол зүйлийг зөв сонгож авах чадвар юм (Goodman,K.1967, Reading Specialist). Тэгэхээр унших өөрөө өргөн хүрээтэй ойлголт учраас судлаачид уншихыг зөвхөн хэлний суурь чадвар гэж ойлгодоггүй, сурах арга барил (Ш.Ичинхорлоо), оюуны нарийн төвөгтэй процесс (В.А.Сухомлинский), оюуны үйл (Brown, Torrance,E.P), урлаг (С.И.Поварнин) гэх мэтээр ойлгож тодорхойлсон. Харин унших чадварыг олон улсад эхийн хүрээнд өгөгдсөн агуулгыг шууд ашиглах (мэдээллийг хайх, олох, мэдээллийг нэгтгэх тайлбарлах), гадаад мэдлэгийг нэмж ашиглах (мэдээллийг эргэцүүлэх, үнэлэх) гэсэн бүтэц хүрээгээр үнэлж байна (Энхтүвшин, 2016, х.338). Ямартай ч унших бол хүний нэн чухал хэрэгцээний нэг, бас боловсролын чухал хэмжүүр, зүгээр утгын код тайлж унших биш уншаад ойлгох, гэгээрэх явдал. Унших чадвар сул байх нь математикийн сурлагын амжилтад шууд нөлөөлж байсан бол харин математикийн чадвар сул байх нь унших чадварт төдийлөн нөлөөлөхгүй гэдгийг судлаачид тогтоосон (БСШУЯ, Дэлхийн банк, 2018, х.9).

Тиймээс унших чадварыг чухалчилж, 2013, 2019 оны хөтөлбөр боловсруулахдаа унших чадвараар хүлээгдэж байгаа үр дүнг дараах байдлаар тодорхойлсон.

Б1.Төрөл бүрийн эхийг уншиж агуулгыг ойлгох

Б2. Эхээс чухал хэсгийг ялгаж өөрийнхөөрөө тайлбарлах, зохиолчийн хэлэх гэсэн санааг тунгаан бодож, гол санааг тайлбарлах

Б3. Баатрын зан чанарыг үнэлж, өөрийн зан чанартай харьцуулан эргэцүүлэн бодох

Б4. Үг, өгүүлбэр, эхийн утгыг ойлгосны үндсэн дээр уран унших

Б5. Уншсанаа бусадтай хуваалцан, санаа бодлоо солилцох

Б6. Зохиолын баатрыг төсөөлөхдөө өөрийн хандлага, үзэл бодлоо илэрхийлэх, үйл явдлыг таамаглах

Харин 2017, 2019 онд олон улсын уншихын нийгэмлэгийн EGRA (early read reading assesment)-гийн судалгаа үндэсний хэмжээнд хийгдэж дараах үр дүн гарсан. 9 даалгавраар боловсруулсны эхний 5 даалгавар зөв, хурдан унших чанарын үзүүлэлт, 6, 7 дугаар даалгавар нь хурдан, ойлгож унших, 8 дугаар даалгавар сонсоод ойлгох, 9 дэх даалгавар зөв бичих чадварын үзүүлэлт.

Давтан хийгдсэн судалгаа 1,2 дугаар ангид унших чадварыг хөгжүүлэх арга зүй хангалттай бусаас суралцагч унших арга барилтай болж чадахгүй байгааг харуулсан. Харин цаашид уншиж сурахад юу нөлөөлж байгааг илрүүлэх зорилгоор лавшруулан 3 дугаар ангийн суралцагчийн ойлгож унших чадвар, багшийн унших чадварыг хөгжүүлж буй арга зүйг судаллаа. Багш нарын асуулгын судалгаанд хот, хөдөөгийн 113 багш, фокус ярилцлагыг шууд ба цахим хэлбэрээр 2 удаа хийж 77 багш хамруулсан. Харин суралцагчаас судалгаа авахдаа, унших чадвар, түүнд хандах хандлагыг тандах, ташаа ойлголтыг баримжаалах зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 3-4 насны 3 хүүхэд, хот, хөдөөгийн ердийн сургалттай 2 ангийн 76 суралцагчийн ойлгож унших чадварыг даалгавар бүхий тестээр уншуулж, даалгавар гүйцэтгүүлж тогтоолоо. Чанарын судалгааны өгөгдөл цуглуулах зорилгоор хичээлийн үйлийн судалгаа, суралцагчийн ойлгож унших үйлийн судалгаа хийж нэгтгэсэн.


Суралцагчийн унших чадварын чанар

Зарим эцэг эхчүүд үг тогтоолгож байгаагаа уншиж сурч байгаа үйлтэй хольж болохгүй. Унших бол хүртэхүй, сэтгэхүйн үйл. Үг, өгүүлбэр тогтоолгох үйл харааны ойг хөгжүүлж буй идэвхтэй арга гэж ойлгох. Учир нь монгол хэл бол зургийн бичиг биш авиааны бичиг. Зургийн бичигтэй бичгийн хэл болон хэлний тодорхой чадвартай суралцагчдад 2 дахь хэлийг заахад бүтэн үгийн аргыг хэрэглэдэг. Үүнээс үндэслэж хэлэнд суралцагчийн хэл, сэтгэхүй, оюуны хөгжлийн онцлог, ямар хэлэнд сургах гэж буй тэр хэлнийхээ онцлогийг таньж байж арга зүйгээ багш боловсруулах юмаа. Уншиж сурах эхний алхам авиагаа зөв дуудах бөгөөд авиа зөв дууддаг бол хялбар зөв уншиж сурдаг. Түүнчлэн авиаг зөв дуудахгүй бол зөв бичиж сурахгүй байгааг ч үйлийн судалгаа харуулж байна. Зөв уншуулж сургахад авиааны задлаг нийлэг арга чухал учраас энэхүү аргыг хэрэглэж буй үйлийг судалгааны явцад хичээлийн судалгаа болгон, 3

дугаар ангид унших чадварыг хөгжүүлэхэд ямар аргыг ашиглаж буйг үйлийн судалгааны аргаар судалсан.

XIX зуунд К.Д. Ушинскийн боловсруулсан авиа, үсэг таниулах авианы задлаг нийлэг аргыг 35 авиа, үсгийг таниулахад ашиглаж байгаа бөгөөд энэ аргын хэрэглээ, багшийн арга зүй уншиж сурахад хэрхэн нөлөөлж байгааг судалбал: (36 багшийн судалгаа).


Зураг 1 Зөв уншуулж сургах багшийн арга зүй (хувиар)



Оролцогч багш нарын 95,5 % нь авианы задлаг нийлэг аргыг ашигладаг. Харин 38 % нь авианы задлаг нийлэг аргыг эрэмбэлсэн аргачлалаар ашигладаг бол 57,5 % задлаг нийлэг аргын үйлийн дэсийн дагуу ашигладаггүй байна. Үүнээс үндэслэж багш нар авиа таниулахдаа задлаг нийлэг аргыг чухалчлахаас илүүтэй өөрийн арга барилыг чухалчилдаг байна. Түүнчлэн үсгийн аргад тулгуурладаг багш 31,5 % байгаа зэргээс харахад уншиж сурахын эхлэл авианы зөв дуудлага гэдгийг ойлгоогүйгээс 2-р ангид суралцаж буй сурагч уншиж сураагүй байлаа. Уншиж сурахын амин чанар авианы зөв дуудлага бөгөөд үүнийг багш хэрхэн чухалчилдгийг илрүүлэх зорилготой дээрх судалгааг авсан. Авиаг зөв дуудаж сураагүй бол зөв уншихгүй, зөв уншихгүй бол хурдан унших цаашилбал ойлгож унших гээд унших чадварын чанар хангалтгүй болно. Хурд болон ойлгоц хоёрыг нэг жинлүүрт тавилаа гэж төсөөлье. Нэг талыг хүчилбэл нөгөө нь дээшээ өргөгдөн тэнцвэрээ алдана, гэхдээ хурд, ойлгоцыг нэг зэрэг хөгжүүлэх боломжгүй ч хурдаа эхэлж анхааран хөгжүүлбэл ойлгоц, хурдтай зэрэгцэн хөгжинө (Хатанбаатар Х., 2009, х.33). Үүнийг EGRA-гийн судалгаа (Бага боловсролын унших болон математик суурь чадварын олон улсын үнэлгээний тайлан)-ны үр дүнд хийсэн задлан шинжлэлээс харж болно. Давтамжтай судалгаагаар их зөрүү гараагүйг ажиглаж болно. Эхний судалгааг 2016 оноос боловсруулан туршиж 2017 онд 21 аймаг, Улаанбаатарын 2897 сурагчаас, тодорхой арга зүй сургалт явуулж, 2019 онд Баян-Өлгийгөөс бусад аймаг, Улаанбаатарын 6447 суралцагчаас судалгаа авсан. Судалгаа унших чадвар төдийлөн хангалттай биш, арга зүй ч оновчтой, тодорхой бус гэж дүгнэхийн зэрэгцээ сонсоод ойлгох чадвар харьцангуй илүү байгаа нь хүүхдэд ойлгох

чадвар муугүй, харин ойлгож унших чадвар сайнгүй байгаа нь уншлагын хурд, унших чадварыг хөгжүүлж байгаа арга зүйг шинэчлэх хэрэгтэйг харуулж байна. Давтамжтай хийгдсэн унших чадварын үнэлгээний дүнг үзүүлбэл:

Зураг 2 EGRA-гаар хийсэн судалгааны дүн




Энэхүү судалгааны үр дүнд баримжаалж 3 дугаар ангийн сурагчдаас судалгаа авч уншлагын хурдыг харьцуулахын зэрэгцээ ойлгож унших чадвар хэр байгааг судалсан. Судалгаа 4 даалгавартай

1. Хурдан, ойлгож унших (минутын уншлага)
2. Эх дэх танил бус үгийг хам орчноос таамаглан тайлбарлах
3. Ойлгох түвшний 2, учир шалтгааныг олох задлан шинжлэх түвшний асуулт 2, үнэлгээ хийх 1 асуултад хариулах
4. Эхээс гол, шинэ санаа, мэдээллийг зэрэгцүүлсэн тэмдэглэл хийж бичих

Суралцагчаар уншуулах эхэд тавигдах шаардлага улс орон, хэлний онцлог ялгахгүйгээр нас, сэтгэхүй, оюуны хөгжил, сурах үйлийн онцлогт тохирсон байхыг чухалчилдаг түгээмэл шаардлагыг дурдвал эх дэх үгийн тоо, танил бус үг нийт үгийн сангийн харьцаа, үг, өгүүлбэрийн хэмжээ, эхийн агуулга, асуулт зохиох боломж, асуудал дэвшүүлсэн байдал зэргийг дурдсан байдаг. Үүнээс үндэслэн улс орнууд стандарт тогтоосон байна. Тухайлбал: Унших хурд гуравдугаар ангид Куба улсад 60, Энэтхэг 49, Мексик 80, Монгол улсад 75-85 гэж тогтоосон (Reading Fluency Measurements in EFA, FTI Partner Countries; Outcomes and improvement Prospects, 2011). Ямар хэлтэй вэ гэдгээс үл хамаарч хурдан унших, хурдан унших нь ойлгож унших чадвар, урнаар мэдэрч уншихад чадварт нөлөөлдгийг судлаачид хэдэнтэй өгүүлсэн байдаг. Тиймээс гуравдугаар ангийн хурдан унших чадварын стандартын тоо хол зөрөөгүй. Судалгаанд ашигласан даалгавар хэн нэгэн уншигч ямар ч эхийг уншихдаа хийх үйл бөгөөд энэ нь уншигчийг өөрийгөө хөгжүүлэхэд унших чадвараа ашиглаж байгааг илэрхийлнэ. Гуравдугаар ангид ойлгож унших чадварыг чухалчилдаг учраас 4 даалгаврын 3 нь ойлгож уншихад чиглэсэн. Түүнчлэн ямар хэл вэ гэдгээс үл хамааран унших чадвар гэдэг нь мэдээллийн ерөнхий утгыг ойлгохын тулд үгс болон холбогдох эхийг зөв тайлбарлаж, үг хэлэх, мэдээллийг боловсруулах чадварыг хэлнэ (Kuhn & Stahl, 2003) гэснээс эш татан боловсруулахыг оролдсон. Судалгааны арга зүйг унших чадварын үнэлгээний зөвлөмж, цөм хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүнг үндэслэн боловсруулж 1,2,3 ангийн 113 багш, 3 дугаар ангийн 76 суралцагчаас судалгаа авбал 1-3 дугаар ангийн уншлагын дундаж хурд 10-15 үгийн зөрүүтэй, нэг эхийг дор хаяж 3 уншиж байж утгыг бүрэн ойлгодог суралцагч 56 %-ийг эзэлж байна. Ийм тохиолдолд багш уншиж дуусмагц асуулт асуух арга ашиглах тохиромжгүй юм. Харин үйлийн судалгаанд оролцогч багшийн 87% энэ аргыг хэрэглэж байсан. 3дугаар ангийн суралцагчийн уншлагын дундаж хурд 65 үг, эхний удаа уншаад 18% нь, 2 дахь удаа уншаад 63% нь, 3 дахь удаа уншаад 17% нь 4-өөс дээш уншаад 2% нь тус тус ойлгож байсан.

Зураг 3 1-3-р ангийн сурагчдын минутад унших уншлагын дундаж үгийн тоо



Судалгаанд оролцогч 3 дугаар ангийн суралцагчийн минутад уншсан үгийн тооны дээд хязгаар 217, доод хязгаар 18 үг байсан. 18 үг уншиж байгаа суралцагч оюун ухааны бэрхшээлтэй хүүхэд байсан.

Зураг 4 3 дугаар ангийн сурагчдын ойлгож унших чадварын үзүүлэлт



Судалгаанаас харахад 3дугаар ангийн суралцагч эх уншаад уншсан зүйлдээ үнэлгээ хийх, уншсанаа бүтээлчээр тэмдэглэх чадвар сул байгаа нь бүтээлчээр уншиж ойлгох арга зүй хэрэглэдэггүйтэй холбоотой. Уншиж сурахад зөв унших арга хэрэглэхээс эхлээд уншихуйн бүх үйлд сэтгэхүйн үйл хийнэ. 96 үгтэй эхийг уншуулахад 1 минутад уншиж дууссан суралцагч 10 (2 суралцагч асуултад хариулаагүй), уншуулж дуусгаад асуултад хариулахад ойлгох, сэргээн санах доод эрэмбийн асуултад 86% хариулж, задлан шинжлэх 2 асуултад бүрэн хариулсан хүүхэд 23% нь, харин дээд эрэмбийн асуулт болох үнэлгээ хийх асуултад бүрэн хариулсан хүүхэд байхгүй, 40% нь боломжийн хариулт өгсөн. Үүнээс үзэхэд доод эрэмбийн асуултад 86%, дээд эрэмбийн асуултад 34% нь хариулж чадаж байлаа. Дээд эрэмбийн асуултад хариулж чадахгүй байгаа нь уншихыг утгын код тайлах төдийгөөр хязгаарлаж, сэтгэхүйн үйл хийхгүй учир унших бүтээлч үйл болж чадахгүйд хүрч байна. Эхийг ойлгож уншихын тулд суралцагч баялаг үгийн сантай байх ёстой. Гэтэл суралцагчдын 46% үгийн утгаа хам сэдвээс тайлбарлаж чадахгүй байсан (Зураг 4). Үгийн утгаа таниагүй бол эхийг ойлгож уншихад бэрхшээлтэй болдог. Харин үгийн утгыг танихын тулд дахин унших, дахин уншихдаа тэмдэглэгээ хийж унших, тэмдэглэлийн дагуу танил бус үгээ тайлбарлах, толь бичиг ашиглах гээд танил бус үгийн утгыг мэдэх арга ашиглах атал багш өөрийн танил бус гэж таамагласан үгээ тайлбарлаж сонсгох төдийгөөр эх уншуулдаг. Хүүхэд шинэ үг сурах үйлээ гүйцээхийн тулд сурч буй үгийнхээ талаарх холбогдох мэдлэг, мэдээллийг (дуудлага, өгүүлбэр зүй, утга, мэдээллийн харилцааны орчин) нэн түрүүнд оюун сэтгэхүүдээ (in the mind) буулгасан байх ёстой (Asimina, M. Julie, E. 2010, p.12). Багшийн хэрэглэж

буй аргыг суралцагчдад хэрхэн нөлөөлж байгааг баримжаалахын тулд багшийн хичээлд сууж тэмдэглэл хөтөлсөн билээ. Асуулгын судалгаа багш бүтээлчээр ойлгож унших аргыг нэрлэж байгаа ч үйлийн судалгаа түүнийг хэрэглэдэг эсэхэд эргэлзээ төрүүлсэн юм. Тиймээс багшийн ойлгож уншуулах чадварыг хөгжүүлж буй аргын судалгааг үйлийн судалгаа хийх, тэмдэглэл хөтлөхөөс гадна асуулга авч, үйлийн судалгаа, багшийн асуулга, фокус ярилцлагыг харьцуулан авч үзлээ. Багшийн хичээлд сууж тэмдэглэл хөтлөх хуудас (хүснэгт 1)-ийг боловсруулахдаа Соросын сангаас хэрэгжүүлж байсан “Бүтээлч сэтгэлгээний арга” төслийн 8 цуврал гарын авлага, “Унших 1,2” (2001) гарын авлага, Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх арга зүй” (2010), Бага боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд гаргасан бүтээгдэхүүнүүдийг ашиглахын зэрэгцээ блүүм таксаномийн асуултын загвар, АНУ-ын боловсролын стандарт зэргийг эш үндэс болгон боловсруулсан.

Хүснэгт 1 Ажиглалтын судалгаанаас хийсэн унших чадварыг хөгжүүлэх аргын тэмдэглэл

Багшийн зааж байсан аргачлалуудыг дэс дараалуулан тэмдэглэгээ хийхэд:
<i>1. Чухал хэсгийг олохын тулд гүйлгэн уншихдаа</i>
- Уншиж эхлэхийн өмнө унших зорилгын талаар бодох - Унших явцдаа таамаглал дэвшүүлж, тэр таамаглалдаа хариулт хайж гүйлгэн унших - Өөрт хэрэгтэй мэдээллийг олохын тулд гүйлгэн унших - Асуултад хариулахын тулд гүйлгэн уншиж тохирохыг сонгох - Зохиолын аль хэсэг хамгийн чухал мэдээлэл агуулж байна вэ? - Яагаад энэ хэсэг чиний анхаарлыг их татав? - Энэ зохиол өвөрмөц гэдгийг аль хэсгээр батлах вэ? гэх мэт асуултын дагуу ярилцах
<i>2. Чухал хэсгийг олохын тулд баатруудын үйлийг харьцуулан уншихдаа</i>
- Бааатруудын хийсэн үйлүүдийг ялгаж жагсаах - Баатруудын хийсэн үйлээс чухлыг ялгах - Нэг баатрын үйлээс чухлыг нь ялгах
<i>3. Эхийг хурааж уншихдаа</i>
- Гол биш гэж үзсэн зүйлээ дарж, хасаж унших - Эхийн зарим хэсгийг яагаад гол биш гэж үзсэн талаар ярилцах - Үлдсэн хэсгийг уншихад ямар ойлголт үлдэж байгааг ярилцах - Гол зүйлийг тэмдэглэж унших - Гол зүйл нь үлдсэн эсэхийг нягталж унших - Гол гэж үзэж байгаагаа тайлбарлах
<i>3. Зааврын дагуу эхийг хурааж бичихдээ</i>
- Баатрын үйл хөдлөлийг хурааж бичих - Нэг баатрын үйл хөдлөлийг хөөж унших, бичих - Эхийг хурааж гол зүйлийг бичих гэх мэт - Уншиж байхдаа гол чухал хэсэг, мэдэхгүй үг, сонирхолтой хэсгийг тэмдэглэж унших
Эхээс баатрын ба зохиогч (өгүүлэгч)-ийн хэлсэн үгийг ялгах
<i>1. Зохиогч (өгүүлэгч)-ийн хэлсэн үгийг ялгахдаа</i>
- Газар орон, цаг хугацааг танилцуулсан хэсэг - Баатрын дотоод, гадаад хөргийг танилцуулсан хэсэг - Үйл явдлын дараалал, холбоосыг хүүрнэсэн хэсэг - Баатруудын ижил болон ялгаа, нөхөр болон дайсагналыг тайлбарласан хэсэг гэх мэтээр ялгах
<i>2. Баатрын хэлсэн үгийг ялгахдаа</i>

- Харилшан яриа бүхий хэсэгт ... юу гэж хэлснээс болоод ...хариулт авах болсон бэ?
- Өөрөө өөртэйгээ ярьж байгаа хэсэгт...тэгж хэлсэн нь өөрийнх нь ямар зан чанарыг тодруулсан бэ? гэх мэт.
Уншсанаа учир шалтгааны дарааллаар тайлбарлан ярих, бичих
<i>1. Уншсанаа учир шалтгааны дарааллаар ярьж бичихдээ</i>
- Энэ эхэд ямар зүйлийг чухалчилсан байна вэ?
- Үүнийг ... хийсэн нь ямар шалтгаантай байсан бэ?
- Зохиогчийн сонгон авсан үг, учир шалтгааныг илрүүлэх гэсэн гэх мэт.
<i>2. Уншсан эхээс гол утга санааг илэрхийлсэн хэсгийг сонгон авч найруулан бичихдээ:</i>
- Эхийн хэсгийг анхааралтай, тогтоож уншаад үйл явдлын дарааллыг алдагдуулахгүй найруулж бичих
- Эхийн эхлэл, төгсгөл хэсгийг анхааралтай уншаад найруулан бичих
- Эхийн гол утга санааг илэрхийлсэн хэсгийг сонсоод найруулж бичих
- Уншсан хэсгээс өөрт таалагдсан хэсгийг тогтоож найруулан бичих, бичихдээ ойролцоо утгатай үгийг ашиглах
- Эхийн үйл явдлын өрнөл дунд дүрүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг гаргахын тулд томчуудын дүр, хүүхдүүдийн дүр, нөхөд, эсрэг дүр, гэр бүлийн холбоотнууд, миний дуртай дүрүүд гэх мэтээр ангилах
- Дүрүүд нэг бүлгээс нөгөөд шилжиж байгаагийн учрыг тайлбарлах
Эхийн учир шалтгаан, холбоо хамаарлыг тодруулсан асуулт асуух
<i>1. Уншсан зохиолын дүрүүдийг харьцуулах, адилтгах, дараалал тогтоох, учир шалтгааныг тогтоох асуулт тавихдаа</i>
- Яагаад? ямар учраас гэх мэт учир шалтгааны асуулт хэрэглэх - Ямар учраас үүнийг ...?
- Ямар асуулт урган гарч ирсэн?
- Яагаад энэ өөрчлөлт гарах болсон бэ?
- Зохиогч чамд ямар асуудлыг бодуулахыг хүссэн бэ? Яагаад?
- Энэ зохиол үнэн байж болох уу? Түүнийг чи яаж мэдэв?
- Чамд хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн ямар дүр байна вэ? Яагаад?
- Өөртэйгөө болон хэн нэгэнтэй адилтгаж болох дүр байна уу? Яагаад?
- Өрөвдсөн, өхөөрдсөн, бахархсан дүр байна уу? Яагаад?
- Зохиогч үгийг яагаад хэрэглэсэн бэ?
- Хэрвээ ... байхгүй байсан бол зохиолч ямар үг хэрэглэх байсан бэ? Яагаад? гэх мэт.
<i>2. Эхэд цаг хугацаа ба орон зай, гол үйл явдлуудын холбоо хамаарлыг тодруулах асуулт тавихдаа</i>
- Үйл явдал хэзээ, хаана өрнөснийг юугаар батлах вэ?
- Бидний амьдарч байгаа цаг үед энэ явдал өрнөх боломжтой юу? Яагаад?
- Өмнө болсон үйл явдал дараагийн үйл явдалтай юугаар холбогдож байна вэ? Яагаад?
- Түүнийг чи яаж мэдсэн бэ? Юугаар батлах вэ?
Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялган таних
<i>1. Зохиолын эхлэл хэсгийг тайлбарлахдаа</i>
- Үүнийг зохиолын эхлэл хэсэг гэдгийг яаж мэдсэнээ тайлбарлах
- Газар орныг танилцуулсан хэсэг байгаа эсэх
- Цаг хугацааг танилцуулсан хэсэг байгаа эсэх
- Баатрыг танилцуулсан хэсэг байгаа эсэх
<i>2. Зохиол цааш яаж үргэлжлэхийг таамаглан ба төсөөлөн бодохдоо</i>
- Зохиолын баатар үүнээс цааш яасан бол?
- Хэрэв үүнээс илүү сайн үйл хийсэн бол тэр нь юу байж болохыг бодъё гэх мэтээр таамаглах
- Хэрэв “...” гэж хэлээгүй бол цааш яах байсан бол гэх мэтээр төсөөлөх
<i>3. Энэ нь зохиолын гол хэсэг гэдгийг яаж баталж болохыг олохдоо</i>
- Зохиолын эхний хэсэгтэй холбоотой ... үйл явдал гарч байгаа болохоор төгсгөл байж болох юм.
- ...энэ үйл явдал нь зохиолын эхлэл хэсгийн үйл явдлыг баталж чадаж байна гэх мэт.


Энэ хэсэг нь зохиолын төгсгөл хэсэг гэдгийг яаж баталж болохыг олохдоо

- Үүнээс цааш зохиол өрнөх боломж байна уу? Яагаад?

- ... энэ хэсгийг цааш үргэлжлүүлэхгүй гэвэл яаж дуусгах нь зөв бол гэх зэргээр ярилцах боломжийг сурагчдад олгохын тулд баг бүрт эдгээр асуултыг өгөх гэх мэт.

Хичээлийн үйлийг тэмдэглэл хийх аргаар судлахад багш нарын ойлгож унших чадварыг хөгжүүлдэг арга 3-5 аргаар хязгаарлагдаж, аргаа нэрлэж чадаж байгаа ч хэрэглээ болгож чаддаггүй нь хичээлийн судалгаанаас харагдаж байсан.

Зураг 5 3 дугаар ангийн багшийн ойлгож унших чадварыг хөгжүүлж буй үйлийн судалгаа




Суралцагчийн хурд нэмэх арга болгож нэгж хугацаанд олон тэмдэгт харах нүдний дасгал, минутын уншлага хааяа хийдэг гэхээс өөр хурдан унших чадварыг хөгжүүлэх арга хэрэглэдэггүй, унших эхээс үүдэн мэдээллийн эх сурвалжтай ажиллуулдаггүй, хэрэгтэй мэдээллээ ялгах, тайлбарлах, чухал ба чухал бусыг ялгах, зэрэгцүүлсэн тэмдэглэл хөтлүүлдэггүй зэрэг нь багш бүтээлчээр ойлгож унших аргыг нэрлэж чадах ч хэрхэн яаж хэрэглэх арга зүй дутмагаас нэрлэсэн арга хэрэглээ болдоггүй нь хичээлийн тэмдэглэл хөтөлсөн

судалгаанаас харагдана. Мөн хичээлийн явцад эхэд тулгуурлан тавьсан асуултыг нь авч үзвээс сэргээн санах, ойлгох, хэрэглээний түвшний асуулт 68%, задлан шинжлэх түвшний асуулт 19%, үнэлгээ хийх асуулт 4%, бүтээх түвшний асуулт 9 %-ийг эзэлж байсан. Дээд эрэмбийн асуултыг багш боловсруулж асуух чадвар сайнгүй байгаа нь эхийг бүрэн гүйцэд ойлгож унших, бүтээлчээр унших чадварыг хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг хэрэгтэй байгааг харуулахын зэрэгцээ нэгэнт багш хэрэглэдэггүй бол хүүхэд бас хөгжихгүй, шууд хамааралтай болохыг судалгаа харуулж байна.

Харин багшаас асуулгын судалгаа авахад тэдэнд унших чадварыг хөгжүүлэхэд хэрэгтэй байгаа зүйл нь арга зүй. Түүнчлэн суралцагчийнхаа унших хурдыг нэмэх гэж хариулснаас үзэхэд багш нарын 55 % нь унших чадварыг хөгжүүлэхэд арга зүйгээр багш нарыг дэмжих хэрэгцээ байгааг харуулж байна. Унших арга зүйгээс унших арга барил бий болно (Zamel,V. 1992, p.464).

Зураг 6 Ойлгож унших чадварт нөлөөлөх хүчин зүйлүүд



Суралцагчийн унших чадварт нөлөөлж байгаа бас нэг хүчин зүйл сургалтын эх бөгөөд зарим эхийг бүтээлчээр ашиглах, эрэлхийлэх, үнэлгээ хийх, задлан шинжлэх асуулт хүртэл зохиоход боломжгүй эхүүд байдаг. Тиймээс сургалтын эхийг судлах, тодорхой шалгуур боловсруулах хэрэгтэй. Унших чадварын чанарын нэг үзүүлэлт хурд хэмээн дээр өгүүлсэн билээ. Хурдан уншихгүй бол эхээ ойлгохгүй. Уншиж ойлгох гээд хурдаа хасвал ойлгож уншихгүй гэдгийг зүй тогтол бүхий ойлголт хэмээн үзэх нь чухал. Сүүлийн цогцолборыг ойлгож унших гэж цагаа барж байтал түрүүчийнх нь мартагдана. Нэгэнт холбоо хамаарал бүхий цогцолборууд учраас нэгийг нь ойлгохгүй бол эхийг бүхэлд нь ойлгохгүйд хүрнэ. Суралцагчдад зориулсан эх уншиж ойлгоход хялбар, алхам алхмаар ойлгож унших чадвараа ахиулахуйц, уншиж байгаа зүйлээсээ баяр баясгалан, таатай мэдрэмж авахуйц байх ёстой (Mufidah,I.A. 2013, p.199). Түүнчлэн багаар ойлгож унших чадварыг хөгжүүлэх арга зүй хэрэглэвэл илүү үр дүнтэй гэх мэтээр судлаачид үзсэн байдгаас үзэхэд унших чадварт нөлөөлөх хүчин зүйл цөөнгүй. Судлаачид унших чадвараа хөгжүүлэхийн тулд тогтмол уншлага хэрэгтэйг ч

дурдсан байдаг. Гэтэл багш нар монгол хэлний хичээлийн 80%-ийг бичих, зөв бичих дүрмийг тайлбарлах, эхээс дүрэмтэй холбоотой үгийг олох, зохиох найруулах, асуултад хариулж бичих, эхийг хураах дэлгэрүүлэх, хэл зүйн ойлголтоо бататгах, жишээ баримтаар батлан бичихэд зориулдаг гэсэн байна. Тухайлбал нэг хэрэглээний эхийг бичиж сурахад 8 цаг зарцуулах атал энэ хугацаанд 2 эх л уншиж ойлгох, хэрэглээ болгоход зориулдаг байна. Басхүү эхийг ойлгож уншихад анхаарал чухал болохыг багш нар дурджээ. Харин төрөл бүрийн эх уншдаг хүүхдийн унших чадвар өндөр гэдгийг PISA-гийн судалгаа харуулсныг мартаж үл болно.

Судалгааны үр дүн

Судалгааны үр дүнг дараах зүйлээр тодорхойллоо.

1. Унших хурдыг хөгжүүлэх арга болгож зөвхөн минутын уншлага авдгаас хурдан унших явцдаа ойлгож уншдаггүй (зураг 2, 3, 4). Судалгаанд хамрагдсан 76 суралцагчийн 14 суралцагч эхний уншилтаар бүрэн ойлгосон бол 48 суралцагч буюу 63% нь 2 удаа уншиж байж бүрэн ойлгосон. Тиймээс уншлагын хурдыг ахиулах цэгт төвлөрч унших, нүдний харах талбайг ихэсгэх дасгалууд, мөр дэх үгийн тоог ихэсгэх арга, утгат хэсгээр зааглан унших арга, зургаар харах талбайг зааглах аргаар хурдыг нэмэх, ойлгож уншсаныг нь илрүүлэх задлан шинжлэх, үнэлгээ хийх асуулт боловсруулж хэрэглэх
2. Ойлгож унших чадварыг хөгжүүлэх аргыг багш цаг зарцуулан хэрэглэдэг байх. Багшийн хэрэглэсэн ерийн уншлагыг сэтгэхүйн үйл болгон чиглүүлсэн арга, суралцагчийн эхийг бүтээлчээр унших арга барил болж тэднийг хөгжүүлдэг болохыг судалгаа баталсан (зураг 4,5). Багш дээд эрэмбийн асуулт бага (зураг 3) тавьдаг учраас, түүнчлэн цаг хомс гэсэн шалтгаанаар эхийг нэг уншаад шууд асуулт тавьж ярилцах, эхийг хураах, дэлгэрүүлэх, дүрийг шүүн тунгаах, учир шалтгааныг тайлбарлах арга (Зураг 4) зонхилдгоос мэдээлэлд боловсруулалт хийх, мэдээллийн чухал ба чухал бусыг ялгах, мэдээллийн эх сурвалжтай ажиллах, задлан шинжлэх, өөрийн гэсэн үнэлгээ дүгнэлт өгөх чадвар сул байлаа.
3. Багш өөрийн хэрэгцээг тодорхойлохдоо ажиллах арга зүй дутагдаж байгаа тодорхойлохын зэрэгцээ хүүхэд өөрөөс нь болж уншлагын чанар муудсан гэж багш нарын 4 % үзсэнээс үзвэл 3 дугаар ангийн суралцагчийн уншлагын чанар багшийн арга зүй (зураг 4,5) -гээс шууд хамааралтай. Харин анги ахих тутам энэхүү хамаарал багасаж бага ангиас багшийн уншуулахад хэрэглэдэг байсан арга зүй нь тэдний сурах арга барил, мэдээлэлтэй ажиллах, боловсруулалт хийх чадварын үзүүлэлт болдог байна.

Дүгнэлт

Ойлгож унших чадварын чанарын асуудал сайнгүй байгаа нь суралцагч унших чадварт системтэй, тогтолцоо байдлаар суралцах хэрэгтэй байгааг судалгаа харуулж байна. Эхний алхмууд болох зөв, хурдан унших техникийг эзэмшээгүй бол ойлгож уншихад бэрхшээл үүсдэгийг нэг эхийг унших уншлагын хурд, хэдэн удаа уншаад бүрэн ойлгодог болохыг 3 дугаар ангийн ойлгож унших чадварыг судалж тогтоохыг хичээлээ. Нөгөө талаас унших чадварыг хөгжүүлэхэд багшийн хөтөлж буй арга, энэхүү аргыг суралцагч өөрсдийнхөө хөгжих арга барил болгодог. Багшийн арга зүйгээс унших чадварын чанар шууд хамааралтай болохыг судалгаа харуулж байгаа бөгөөд дийлэнх суралцагч уншиж байгаа эхийг ойлгож уншихдаа сэргээн санах, хэрэглэх түвшинд судалдаг байна. Өнөөдөр мэдээллийн олон “урсгалаас” хэрэгтэй мэдээллээ олж авч чадахгүй, чухал, чухал бусыг эрэмбэлж, мэдээлэлд боловсруулалт хийх чадвар сул байгаа нь ойлгож унших чадварыг хөгжүүлэх арга барил бий болгох чанартай сургалтад хамрагдаагүйтэй шууд хамааралтайг үйлийн болон чанарын судалгаа харууллаа. Ойлгож унших чадварын чанарт багшийн арга зүй, зөв, хурдан унших чадвар нөлөөлөхийн зэрэгцээ сургалтын эх, монгол хэлний хичээлээс унших чадварыг хөгжүүлэхэд зарцуулж байгаа цагийг тусгайлан судалж, сургалтын эхийн шалгуур, эх хэлний хичээлийн хөтөлбөрийн үр дүн, унших чадварыг хөгжүүлэхэд оногдох цагийн нормын дахин харах цаг болжээ.

Ном зүй

- Бурмаа, Ц. (2011). *Англи хэл суралцагчдад уншиж ойлгох арга барил эзэмшүүлэх арга зүйн судалгаа*. Улаанбаатар: БИТ
- Хатанбаатар, Х. (2009). *Уншихуйн гайхамшиг*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Энхтүвшин, С. (2016). “PISA-2012”-ийн унших чадварын үнэлгээнд хийсэн анализ ба шилдэг туршлагаас. Боловсролын үнэлгээ, х.336 -350.
- Goodman, K. (1967). Reading: A Psycholinguistic Guessing Game. *Journal of the Reading Specialist* 6(4), p. 126-135.
- Zamel, V. (1992). Writing One’s Way into Reading. *Tesol Quarterly, volume 26, issue 3*, p.463-485.
- Mufidah, I.A. (2013). Student team achievement division (STAD) technique in teaching reading comprehension. *Jurnal Bahasa Lingua Scientia, Vol5,2*, p.199-205
- Asimina, K & Julie, E. (2010). Real world word learning: exploring the development of children’s lexical representations, *Psychology*, 2010, 17(1), p.1-24.
- Kuhn,M.R.,& Stahl,S. (2003). Fluency; A review of developmental and remedial practices. *The Journal of Educational Psychology* , 95, p.3-21.
- БСШУСЯ, Дэлхийн банк. (2017). *Бага ангийн сурагчдын унших болон математикийн суурь чадварын олон улсын үнэлгээ*. Улаанбаатар: Содпресс.

БСШУСЯ, Дэлхийн банк. (2018). *Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга, хэрэгсэл*. Улаанбаатар: Содпресс.

The Quality of Reading Skills of Third Graders

Byambatseren Gaanjuur

Khulunbuir University, Khulunbuir, China

Corresponding author: byatsrn@gmail.com 

Received: 5/15/2020/

Revised: 9/10/2020

Accepted: 9/28/2020

Abstract

Developing the reading skill is closely related to the development of a number of sub-skills such as correct pronunciation of sounds and words, fast-reading techniques, reading comprehension and knowledge acquisition and other reading strategies. In order to help the learner develop these skills, teachers themselves should be well prepared professionally to provide support to their learners in phonetic reading and be aware of reading strategies. Today's classroom reality shows an insufficient support for the development of learners' reading comprehension skills employing very few teaching methods and strategies- limited by only 1-2 methods for the development of the reading speed and 3-5 strategies for the development of the reading skill focusing more on the development of the writing skill giving almost 80% of the classroom time to writing activities.

Key words

Reading skill, fast-reading strategies, higher order thinking question, thinking, methodology
